

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/135/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207, Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuu@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын илрүүлэлт	10
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БЧШ	Боловсролын чанарын шинэчлэл
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.19 № 131
танай 2025.01.17-ны № 57 -т

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА Ч.АРИУНАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Боловсролын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 4 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн тайланг Боловсрол яамнаас 94.7 хувиар дүгнэсэн байна.

011021980

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,035,093.40	68,984,243.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	69,035,093.40	68,984,243.40
354	Хангамжийн материал	69,035,093.40	68,984,243.40
35410	Бичиг хэргийн материал	208,250.00	105,400.00
35420	Аж ахуйн материал	1,512,500.00	1,637,500.00
35440	Түлш, шатах тослох материал	410,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	66,904,343.40	67,241,343.40
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,128,358,090.85	2,493,466,165.94
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,128,358,090.85	2,493,466,165.94
392	Биет хөрөнгө	1,268,098,090.85	1,215,181,165.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,245,253,882.00	1,245,253,882.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(163,984,328.66)	(184,738,560.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	445,296,245.99	462,016,390.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	(267,191,717.68)	(313,869,629.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,777,015.90	48,777,015.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,053,006.70)	(42,257,933.26)
393	Биет бус хөрөнгө	860,260,000.00	1,278,285,000.00
39301	Програм хангамж	3,750,000.00	18,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,750,000.00)	(3,750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	860,260,000.00	1,263,285,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,197,393,184.25	2,562,450,409.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,197,393,184.25	2,562,450,409.34
51	Засгийн газрын хувь оролцоо	2,197,393,184.25	2,562,450,409.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,053,853,243.20	1,456,878,243.20
51101	Өмч: - төрийн	1,053,853,243.20	1,456,878,243.20
512	Хуримтлагдсан үр дүн	1,140,072,645.02	1,102,104,870.11
51210	Өмнөх үеийн үр дүн	1,012,207,155.52	1,140,072,645.02
51220	Тайлант үеийн үр дүн	127,865,489.50	(37,967,774.91)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,467,296.03	3,467,296.03
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,197,393,184.25	2,562,450,409.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,529,577,879.14	9,318,417,522.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,055,947.14	120,186,525.00
120	Нийтлэг татварын бус орлого	300,055,947.14	120,186,525.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,055,947.14	120,186,525.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	120,447,055.97	13,420,245.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	179,608,891.17	106,766,280.00

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,229,521,932.00	9,198,230,997.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,991,840,100.00	7,717,793,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,991,840,100.00	7,717,793,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	237,681,832.00	1,480,437,097.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	197,128,880.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,552,952.00	1,480,437,097.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,393,008,934.13	9,356,385,296.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,393,008,934.13	9,356,385,296.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	969,341,860.33	1,989,046,239.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,582,578.11	837,613,116.66
210101	Үндсэн цалин	298,830,915.15	415,259,458.66
210102	Нэмэгдэл	120,820,796.57	293,043,352.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,442,579.36	72,270,246.00
210104	Урамшуулал	46,488,287.03	57,040,060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,423,291.09	105,993,772.67
210201	Тэтгэврийн даатгал	46,690,508.11	71,207,282.48
210202	Тэтгэмжийн даатгал	4,717,260.66	8,731,462.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,773,649.48	4,485,141.41
210204	Ажилгүйдлийн даатгал	931,133.27	4,218,909.21
210205	Эрүүл мэндийн даатгал	9,310,739.57	17,350,976.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,540,900.00	11,132,531.86
210301	Гэрэл, цахилгаан	3,361,263.09	4,114,351.37
210302	Түлш, халаалт	4,779,754.91	3,967,944.49
210303	Цэвэр, бохир ус	3,399,882.00	3,050,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,409,224.00	73,783,250.00
210401	Бичиг хэрэг	4,119,840.00	2,750,650.00
210402	Тээвэр, шатахуун	3,570,692.00	7,910,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	680,202.00	1,382,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,038,490.00	2,067,770.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал		59,672,280.00
2107	Томилолт, зочны зардал	2,176,000.00	3,134,000.00
210702	Дотоод албан томилолт	2,176,000.00	3,134,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,174,092.00	630,938,992.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,174,092.00	630,938,992.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	310,035,775.13	326,450,575.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,707,221.17	58,828,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	122,087,683.00	197,985,006.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,240,870.96	69,637,069.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,423,667,073.80	7,367,339,057.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,257,141,059.00	6,790,738,153.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,086,085,691.00	1,407,952,153.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,093,483,968.00	4,760,225,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	77,571,400.00	622,560,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	166,526,014.80	576,600,903.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	166,526,014.80	576,600,903.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	136,568,945.01	(37,967,774.91)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,703,455.51	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,703,455.51	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,703,455.51)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	127,865,489.50	(37,967,774.91)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,229,521,932.00	9,198,230,997.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,229,521,932.00	9,198,230,997.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,991,840,100.00	7,717,793,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,991,840,100.00	7,717,793,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	237,681,832.00	1,480,437,097.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	197,128,880.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,552,952.00	1,480,437,097.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,209,559,032.00	9,179,931,097.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,209,559,032.00	9,179,931,097.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	785,891,958.20	1,812,592,039.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,582,578.11	837,613,116.66
210101	Үндсэн цалин	298,830,915.15	415,259,458.66
210102	Нэмэгдэл	120,820,796.57	293,043,352.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,442,579.36	72,270,246.00
210104	Урамшуулал	46,488,287.03	57,040,060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,423,291.09	105,993,772.67
210201	Тэтгэврийн даатгал	46,690,508.11	71,207,282.48
210202	Тэтгэмжийн даатгал	4,717,260.66	8,731,462.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,773,649.48	4,485,141.41
210204	Ажилгүйдлийн даатгал	931,133.27	4,218,909.21
210205	Эрүүл мэндийн даатгал	9,310,739.57	17,350,976.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,540,900.00	11,132,531.86
210301	Гэрэл, цахилгаан	3,361,263.09	4,114,351.37
210302	Түлш, халаалт	4,779,754.91	3,967,944.49
210303	Цэвэр, бохир ус	3,399,882.00	3,050,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,165,244.00	13,830,120.00
210401	Бичиг хэрэг	1,571,600.00	2,647,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,980,692.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	680,202.00	1,382,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	1,932,750.00	2,299,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,900.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,900.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,176,000.00	3,134,000.00
210702	Дотоод албан томилолт	2,176,000.00	3,134,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,174,092.00	630,938,992.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,174,092.00	630,938,992.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,798,953.00	209,949,506.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,302,670.00	11,964,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	132,496,283.00	197,985,006.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,423,667,073.80	7,367,339,057.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,257,141,059.00	6,790,738,153.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,086,085,691.00	1,407,952,153.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,093,483,968.00	4,760,225,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	77,571,400.00	622,560,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	166,526,014.80	576,600,903.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	166,526,014.80	576,600,903.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,962,900.00	18,299,900.00

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,962,900.00	18,299,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,962,900.00	18,299,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,962,900.00	18,299,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,962,900.00	18,299,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(19,962,900.00)	(18,299,900.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,593,243.20	4,560,555.52	1,011,113,896.03	0.00	1,224,267,694.75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,093,259.49	0.00	1,093,259.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,593,243.20	4,560,555.52	1,012,207,155.52	0.00	1,225,360,954.24
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-1,093,259.49	0.00	0.00	-1,093,259.49
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	845,260,000.00	0.00	0.00	0.00	845,260,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	127,865,489.50	0.00	127,865,489.50
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,053,853,243.20	3,467,296.03	1,140,072,645.02	0.00	2,197,393,184.25
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,053,853,243.20	3,467,296.03	1,140,072,645.02	0.00	2,197,393,184.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,053,853,243.20	3,467,296.03	1,140,072,645.02	0.00	2,197,393,184.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	403,025,000.00	0.00	0.00	0.00	403,025,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-37,967,774.91	0.00	-37,967,774.91
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,456,878,243.20	3,467,296.03	1,102,104,870.11	0.00	2,562,450,409.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,991,840,100.00	2,836,155,542.20	7,717,793,900.00	7,143,375,523.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,991,840,100.00	2,836,155,542.20	7,717,793,900.00	7,143,375,523.69

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,548,100.00	656,014,483.20	1,000,914,600.00	974,637,370.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,642,200.00	540,582,578.11	801,970,100.00	787,147,716.66
210101	Үндсэн цалин	306,224,600.00	298,830,915.15	534,413,800.00	415,259,458.66
210102	Нэмэгдэл	122,037,000.00	120,820,796.57	198,107,400.00	242,577,952.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,747,000.00	74,442,579.36	31,337,100.00	72,270,246.00
210104	Урамшуулал	104,633,600.00	46,488,287.03	38,111,800.00	57,040,060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,448,400.00	65,423,291.09	101,471,400.00	99,685,597.67
210201	Тэтгэврийн даатгал	47,004,000.00	46,690,508.11	67,032,500.00	66,917,723.48
210202	Тэтгэмжийн даатгал	4,611,100.00	4,717,260.66	8,609,700.00	8,226,808.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,688,900.00	3,773,649.48	4,304,900.00	4,113,704.41
210204	Ажилгүйдлийн даатгал	922,200.00	931,133.27	4,304,900.00	4,085,692.21
210205	Эрүүл мэндийн даатгал	9,222,200.00	9,310,739.57	17,219,400.00	16,341,668.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,540,900.00	11,540,900.00	12,017,200.00	11,132,531.86
210301	Гэрэл, цахилгаан	3,547,000.00	3,361,263.09	4,790,100.00	4,114,351.37
210302	Түлш, халаалт	4,411,000.00	4,779,754.91	5,427,400.00	3,967,944.49
210303	Цэвэр, бохир ус	3,582,900.00	3,399,882.00	1,799,700.00	3,050,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,304,600.00	6,304,552.00	18,222,700.00	13,830,120.00
210401	Бичиг хэрэг	1,364,400.00	1,571,600.00	1,338,500.00	2,647,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,974,500.00	2,120,000.00	14,956,000.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	208,500.00	680,202.00	204,500.00	1,382,550.00
210404	Ном, хэвлэл	77,800.00	-	76,300.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	660,800.00	-	648,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,018,600.00	1,932,750.00	999,200.00	2,299,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	19,993,800.00	-	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,993,800.00	-	-
2107	Томилголт, зочны зардал	2,200,600.00	2,176,000.00	3,196,800.00	3,134,000.00
210702	Дотоод албан томилолт	2,200,600.00	2,176,000.00	3,196,800.00	3,134,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	591,600.00	174,092.00	35,580,400.00	31,487,854.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	591,600.00	174,092.00	35,580,400.00	31,487,854.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,819,800.00	9,819,270.00	28,456,000.00	28,219,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,552,700.00	4,552,670.00	4,466,200.00	4,264,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,267,100.00	5,266,600.00	23,989,800.00	23,955,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,326,292,000.00	2,180,141,059.00	6,716,879,300.00	6,168,738,153.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,326,292,000.00	2,180,141,059.00	6,716,879,300.00	6,168,738,153.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,168,040,400.00	1,086,085,691.00	1,551,698,800.00	1,407,952,153.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,157,680,200.00	1,093,483,968.00	5,164,620,000.00	4,760,225,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	571,400.00	571,400.00	560,500.00	560,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	7,717,793,900.00	7,143,375,523.69
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	7,717,793,900.00	7,143,375,523.69
131001	Улсын төсвөөс санхүүжих			7,717,793,900.00	7,143,375,523.69
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31.00	31.00	31.00	27.00
620001	Удирдах ажиллан	3.00	3.00	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажиллан	23.00	23.00	23.00	19.00
620003	Үйлчлэх ажиллан	5.00	5.00	5.00	5.00

2.5.1 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,478,254,569.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,478,254,569.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,254,569.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,465,400.00
210102	Нэмэгдэл	50,465,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,308,175.00
210201	Тэтгэврийн даатгал	4,289,559.00
210202	Тэтгэмжийн даатгал	504,654.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	371,437.00
210204	Ажилгүйдлийн даатгал	133,217.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,009,308.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	614,451,138.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,451,138.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,029,856.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	174,029,856.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	622,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	622,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	622,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,182,527.60
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,182,527.60
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,480,437,097.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,480,437,097.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,480,437,097.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 418,025.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

- Тайлант хугацаанд газрын нэгдсэн санд бүртгэлтэй 22,651 м² байгууллагын эзэмшлийн гэрчилгээтэй 403,025.0 мянган төгрөгийн газрыг бүртгэл, тайланд тусгахдаа Засгийн газрын сан дансанд тусгаагүй байна. Энэ нь Сангийн Сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн Ангилал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Байгууллагын цалин хөлсний нэгдсэн хяналт, төлөвлөлт хийхэд ашиглагдах POWER BI программыг үндсэн хөрөнгийн бүртгэлд орлогдож аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар илэрсэн нийт 142,208.1 мянган төгрөгийн зөрчил²-д 12,833.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 129,375.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

1. Бусад хангамжийн материалын бүртгэлд 9.0 сая төгрөгийн үнэ бүхий "Халх гол дууны бүтээл" нэртэй материалын шинж чанарыг агуулаагүй зүйлийг бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС 12-д Бараа материал гэдэг нь "Үйлдвэрлэлийн процесст болон үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдах материал эсвэл хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгийг хэлнэ" гэсэн тодорхойлолтыг хангахгүй, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг мөрдөж ажиллаагүй, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Тус байгууллагын нягтлан бодогч, нярав нарт 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэгдсэн гэх үндэслэлээр нийт 3,833.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын цалин хөлсний нэгдсэн хяналт, төлөвлөлт хийхэд ашиглагдах 15,000.0 мянган төгрөгийн POWER BI программыг үндсэн хөрөнгийн бүртгэлд орлогдож аваагүй, цаашид хэвийн ажиллах талаар нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу шинэчлэлтийн ажлыг хийгээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төсвийн тухай хуулийн 16 дугаар 16.5.2 дахь "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг данс бүртгэлд тусгах, программын шинэчлэлт, сайжруулалтыг хийж байх зөвлөмж өгөх.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн данс бүртгэлд 2005-2013 онд ашиглалтад орсон элэгдлийн хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн нийт 114,375.1 мянган

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн 208 ширхэг хөрөнгийг данс бүртгэлээс хасах саналаа эрх бүхий байгууллагад тавьж, шийдвэр гаргуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх "..... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын эзэмшлийн гэрчилгээтэй 403,025.0 мянган төгрөгийн газрыг бүртгэл, тайланд бүртгэхдээ Засгийн газрын сан дансанд тусгаагүй байна.	1	403,025.0			1	403,025.0	1	403,025.0				
POWER BI программыг үндсэн хөрөнгийн бүртгэлд орлогдож аваагүй	1	15,000.0	1	15,000.0			1	15,000.0				
дүн	2	418,025.0	1	15,000.0	1	403,025.0	2	418,025.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлагатай тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
нягтлан бодогч, няравт санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан гэх үндэслэлээр улирлын үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон	1	3,833.0			1	3,833.0						
Хөрөнгийг данс бүртгэлээс хасах саналаа эрх бүхий байгууллагад тавьж, шийдвэр гаргуулаагүй байна.	1	114,375.1					1	114,375.1				
Бусад хангамжийн материалын бүртгэлд 9.0 сая төгрөгийн үнэ бүхий "Халх гол дууны бүтээл" нэртэй материалын шинж чанарыг агуулаагүй зүйлийг бүртгэсэн	1	9,000.0			1	9,000.0						
Хөрөнгийг орлогдож авах, шинэчлэлтийг хийж байх	1	15,000.0					1	15,000.0				
Дүн	4	142,208.1			2	12,833.0	1	129,375.1				



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 5804-2025/135/МА-СТА-ТМЗ.
А 1170308

Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бусад хангамжийн материалын бүртгэлд 9.0 сая төгрөгийн үнэ бүхий "Халх гол дууны бүтээл" нэртэй бараа материалын шинж чанарыг агуулаагүй зүйлийг бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС 12-д Бараа материал гэдэг нь "Үйлдвэрлэлийн процесст болон үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдах материал эсвэл хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгийг хэлнэ" гэсэн тодорхойлолтыг хангахгүй, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалд бүртгэсэн зүйлийг холбогдох байгууллагаар шийдвэр гаргуулж, бүртгэлээс хасах, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 24-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулан ажиллахыг Дорнод аймгийн Боловсролын газрын дарга Ч.Ариунаа, нягтлан бодогч Д.Балжинням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Д.НАРМАНДАХ

Б.ОДХҮҮ



011041430



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 74/2024-2025/135/НА-СТАТ43
А 1170308

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч, нярав нарт 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэгдсэн гэх үндэслэлээр нийт 3,833.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4 "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг мөрдөж ажиллах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Боловсролын газрын дарга Ч.Ариунаа, нягтлан бодогч Д.Балжинням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Б.ОДХҮҮ



2125040166